

**Улаанбаатар хотын  
Цэвэр агаарын санаачлага  
төслийн 2-р үе**

**Байгаль орчин, аялал жуулчлалын яам/ЕСБХБ**

**Евроконсалт Мотт МакДоналд  
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ  
Монголиан Барристерс & Солиситорс ХХК**

**2012-7 сар**





Улаанбаатар хотын  
Цэвэр агаарын санаачлага  
төслийн 2-р үе

Гэрээний дугаар:22384/EBSF2009-09-117/01

Цэвэр агаарын сангийн ажилтнуудын сургалтын хэрэгцээний  
үнэлгээ ба үйл ажиллагааны төлөвлөгөө

2012-7-17

Байгаль орчин, аялал жуулчлалын яам  
ЕСБХБ

**Албан даалгавар: 3.4.9**

БОАЖЯ  
Засгийн газрын II байр  
Нэгдсэн үндэстний гудамж 5/2  
Улаанбаатар -210646  
Монгол улс

ЕСБХБ  
One Exchange Талбай,  
Лондон хот, EC2A 2JN,  
Их Британи

## Боловсруулсан, шинэчилсэн тэмдэглэл

Шинэчилсэн	Огноо	Боловсруулсан	Шалгасан	Баталсан	Тайлбар
0	2012-7-20	Онно вд Хювэл & Д. Эрдэнэ	Гийт де Вилдт		
1					

## Улаанбаатар хотын Цэвэр агаарын санаачлага төслийн 2-р үе

Улаанбаатар хотын гэр хороололд уламжлалт зууханд чанар муутай нүүрс түлэх нь ялангуяа өвлийн саруудад тус хотын агаарын бохирдлын томоохон шалтгаан болдог. Улаанбаатар хотын агаарын чанар нь хотын оршин суугчдын эрүүл мэнд цаашлаад улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Иймд уламжлалт зуухыг утаа бага ялгаруулдаг зуухаар солих, түүхий нүүрсийг боловсруулсан, нүүрсэн суурьтай, утаа бага ялгаруулдаг, хэмнэлт сайтай түлшээр солих нь тулгамдаад байгаа агаарын бохирдлын асуудлын нэлээд хэсгийг богино хугацаанд шийдвэрлэх үр дүнтэй арга хэмжээний нэг гэж үзэх болсон. Боловсруулсан түлшний найдвартай нийлүүлэлт, түлш, зуухыг хослуулах, тэдгээрийг дэмжсэн орчин, стандартуудыг гаргах нь уг арга хэмжээг үр дүнтэй явуулахад зайлшгүй шаардлагатай. Засгийн газар орлуулах түлшний үйл ажиллагааны тодорхой хэсэгт дэмжлэг үзүүлэхийг Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-наас хүссэн юм. ЕСБХБ нь Засгийн газартай 2008 оны 9-р сараас түүхий нүүрсийг боловсруулсан түлшээр орлуулах төлөвлөгөөг боловсруулахаар хамтран ажиллаж эхэлсэн. Уг төлөвлөгөөний гол хэсгүүдийг 2009 оны 6-р сард Засгийн газраар батлуулахаар өргөн барьсан Түлш орлуулах үйл ажиллагааны ерөнхий хүрээнд тусгасан. Засгийн газар Үйл ажиллагааны хүрээний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг зарчмын хувьд баталж, 2010 оны 6-р сард Монгол Улсын их хурал Агаарын багц хуулиудыг батлаж гаргасаны дараа тус банк төслийн II үеийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болж Үйл ажиллагааны ерөнхий хүрээний гол хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх Зөвлөхүүдийг шалгаруулж авах ажлыг гүйцэтгэсэн. Зөвлөхүүд нь Үйл ажиллагааны ерөнхий бүдүүвч (баримт бичиг)-ийн холбогдох хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт хууль эрх зүй, эдийн засаг, техникийн болон чадавхийг бэхжүүлэх шаардлагатай бүхий л тусламж дэмжлэг үзүүлэх зорилготой.

Энэхүү баримт бичгийг дээр нэр заасан төслийн зорилгын хүрээнд, зөвхөн эрх бүхий талуудад зориулан гаргасан болно. Өөр зорилгоор ашиглаж үл болно.

Энэхүү баримт бичгийг ашиглах эрх бүхий талуудаас бусад этгээдүүд өөр зорилгоор ашигласнаас үүдэн гарсан үр дагавар, бусад талуудаас нийлүүлсэн мэдээллийн алдаа мадаг, орхигдсон зүйлсийн талаар манай тал ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Энэхүү баримт бичиг нь нууц мэдээлэл агуулсан оюуны өмчийн бүтээл болно. Бидний болон энэ баримтыг бэлтгэсэн талын зөвшөөрөлгүйгээр бусад талуудад үзүүлэхийг хориглоно.

# Гарчиг

	<b>Page</b>
<b>1 УДИРТГАЛ</b> .....	<b>1</b>
<b>2 СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ</b> .....	<b>2</b>
2.1 АРГА ЗҮЙ .....	2
2.2 СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....	2
2.3 ЧАДАВХИЙН БУСАД ХЭРЭГЦЭЭ .....	3
<b>2.3.1 Төсвийн төлөвлөлт</b> .....	3
2.3.2 Эдийн засгийн загварчлал .....	3
2.3.3 Агаарын бохирдлын тухай үндсэн ойлголт .....	3
2.3.4 Мэдээлэл сурталчилгаа (Advocacy).....	3
2.3.5 Мониторинг, үнэлгээ.....	4
<b>3 ЧАДАВХИ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	<b>5</b>
3.1 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТУСГАГДАХ АСУУДЛУУД.....	5
3.1.1 Агаарын тухай хууль тогтоомж.....	5
3.1.2 Байгаль орчны санхүүжилт .....	6
3.1.3 Агаарын бохирдлын талаарх үндсэн ойлголт.....	6
3.2 Үйл ажиллагааны ба менежментийн асуудлууд.....	6
3.3 НӨӨЦ.....	7
<b>ХАВСРАЛТ</b>	
Хавсралт 1 Нэмэлт тэмдэглэл .....	9

# Товчилсон үгс

БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ДДБОС	Даян дэлхийн байгаль орчны сан
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
ЦАС	Цэвэр агаарын сан
УБЦАС II	Улаанбаатар хотын Цэвэр агаарын санаачлага 2 төсөл
УИХ	Улсын их хурал

# Оршил

Улаанбаатар хотын Цэвэр агаарын санаачлага 2 (УБЦАС-II) төслөөс Цэвэр агаарын сан (ЦАС)-гийн ажилтнуудыг оролцуулан оролцооны аргаар Сангийн ажилтнуудын сургалтын хэрэгцээг үнэлэв. Уг үнэлгээг ажилтнуудын оролцоотой явуулсан нь тэдэнд өөрсдийн ур чадвараа аль хэсэгт илүү хөгжүүлэх шаардлага байгааг олж тогтоох боломж олголоо. Түүнчлэн төслийн зүгээс Сангийн ажилтнуудын техникийн ур чадвар ямар түвшинд байгааг тогтоох боломж олгов. Уг ажлын үр дүнг үндэслэн энэхүү сургалтын хэрэгцээний үнэлгээний тайлан болон сургалтын үйл ажиллагааны цаашдын төлөвлөгөөг боловсруулан гаргалаа. Иймд энэ тайлан, төлөвлөгөө нь цаашид ЦАС-гийн багийн ур чадвар, ажлын гүйцэтгэлийг сайжруулахад чиглүүлэх гол баримт бичиг болно. ЦАС-гийн ажилтнууд Сангийн үйл ажиллагааг оновчтой явуулахад агаарын бохирдлын менежмент ба санхүүжилтийн асуудлаар олон улсын туршлага, сайн жишээнээс суралцан илүү сайн ойлголттой болж, өөрийн орны загвар бий болгоход ашиглахыг хүсч байна.



# 1 Удиртгал

УБЦАС-2 төсөл нь ЦАС-гийн бүтэц зохион байгуулалт, чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Чадавхийн гол хэрэгцээг тодорхойлох зорилгоор Сангийн ажилтнуудын оролцоотой сургалтын хэрэгцээг үнэлэв. Эхлээд ажилтан бүртэй уулзан тэдний ажлын чиг үүрэг, үндсэн үүргүүдийн нь талаар ярилцлаа. Үүний дараа тэдний сургалтын хэрэгцээний асуудлыг хэлэлцэх нэгдсэн уулзалтыг зохион байгуулав. Эдгээр уулзалт, ярилцлагын дараа ажилтнууд өөрсдийн саналаа төслийн багт хүргүүлэв. Сургалтын хэрэгцээг тогтоосны үндсэн дээр чадавхи бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан гаргалаа. Энэ тайланд эхлээд сургалтын хэрэгцээний үнэлгээ, түүний үр дүнгийн талаар дараа нь үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус оруулав.

## 2 Сургалтын хэрэгцээний үнэлгээ

Энэ хэсэгт сургалтын хэрэгцээний үнэлгээг хэрхэн явуулсан болон үнэлгээний үр дүнгийн талаар оруулав.

### 2.1 Арга зүй

Төслийн үйл ажиллагаа эхлэх үед төслийн баг ЦАС-гийн ажилтнуудтай нэг бүрчлэн уулзан тэдний ажлын чиг үүрэг, гүйцэтгэж буй ажил, тэдний Ажлын байрны тодорхойлолтонд заагдсан ажил үүрэг, хариуцлагын талаар ярилцсан. Түүний дараа Сангийн бүтэц зохион байгуулалтын бүдүүвчийг одоогийн ажиллаж байгаа ажилтнууд болон төслийн ажилтнуудын Ажил үүргийн хуваарийн хамт боловсруулан гаргав (Албан даалгавар 3.4.3). Иймд сургалтын хэрэгцээг тус Сангийн шинэчилсэн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэгт үндэслэн явууллаа. Ажилтнуудтай уулзсны дараа Сангийн бүтэц зохион байгуулалтын шинэчилсэн хувилбарыг хэлэлцэх, тэдний сургалтын хэрэгцээний талаар санал авах нэгдсэн уулзалт хийсэн. Уулзалтын дараа ЦАС-гийн баг асуудлыг үргэжлүүлэн хэлэлцэж, өөрсдийн санал бодлоо нэгтгэн сургалтын хэрэгцээний саналаа бичгээр ирүүлсэн.

### 2.2 Сургалтын хэрэгцээний үнэлгээний үр дүн

ЦАС-гийн ажилтнууд дараахи асуудлыг сургалтын хэрэгцээний нэн тэргүүний асуудлууд гэж тодорхойлж байна. Үүнд:

- Агаарын бохирдлын менежментийн асуудлаар олон улсын туршлага, асуудлыг хэрхэн зохицуулж ирсэн жишээ, арга замыг судалж, ижил төрлийн Сангуудыг үйл ажиллагааны талаар илүү сайн ойлголттой болох хэрэгтэй байна. Иймд олон улсын сургалт буюу туршлага солилцох аялалыг зохион байгуулах. ЦАС-гийн Гүйцэтгэх захирал “ажилтнуудаа олон улсын туршлагатай танилцуулж, сайн ойлголттой болгосны үндсэн дээр ЦАС-гаас нийлүүлж байгаа бараа, үйлчилгээ тэдгээрийн үйл ажиллагаа, мониторингийг оновчтой явуулах болно” гэж үзэж байна.
- Түүнчлэн ЦАС-гийн ажилтнуудын ажил үүрэгтэй холбоотой асуудлаар хоёр долоо хоног ба түүнээс дээш хугацаагаар гадаадын холбогдох сургалтанд хамруулах гэж төлөвлөсөн байна. Энэ нь тухайн сургалтанд хамрагдсан хүмүүст олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын гэрчилгээ, дипломтой болох боломж олгох болно гэж үзэж байна.
- Ажилтнууд бусад орнуудын агаарын бохирдол/цэвэр агаарын актууд, хууль эрх зүйн орчны талаар сайн ойлголттой болох, мэдлэгээ дээшлүүлэх хэрэгтэй байна. Тэд ялангуяа Европын орнуудын хууль тогтоомж болон бүтэц зохион байгуулалтын бусад асуудлуудын талаар сайн ойлголттой болохыг зорьж байна. Эдгээрийг судалж мэдсэнээр Европын орнуудын хууль эрх зүйн тогтолцоог өөрийн орны агаарын хууль тогтоомжтой, тогтолцоотой харьцуулах боломж бүрдэнэ. Тэдний суралцаж, мэдэхийг хүсч байгаа өөр нэг асуудал бол мониторинг ба хариуцлагын тогтолцоог хэрхэн бүрдүүлж байгааг судлах юм. Эдгээр асуудлын талаар олж мэдсэн зүйлээ тэд өөрийн орны тогтолцоог сайжруулах, боловсронгуй болгоход ашиглахыг зорьж байна.
- Ажилтнууд олон улсын туршлага, мэдлэгээс суралцахыг чухалчилж байгаа ч тэд агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг санхүүжүүлдэг үндэсний арга туршлага бий болгохын тулд өөрийн оронд ажилладаг бусад Сангуудын үйл ажиллагаанаас

суралцахыг зорилго тавьж байна. Иймд ЦАС-гийн ажилтнууд Монгол оронд үйл ажиллагаагаа явуулж байгаа бусад Сангуудын туршлага сайн жишээнээс суралцаж өөрийн Сангийн үйл ажиллагааг Тусгай сангийн тухай хууль тогтоомжийн хүрээнд явуулдаг болохыг зорьж байна.

- ЦАС-гийн ажилтнууд үндсэн/гол үйл ажиллагааг хамруулсан улирлын сургалтын хөтөлбөрөө гаргах хэрэгтэй гэж үзэж байна. Үүний дагуу ажилтнууд өөрсдийн хариуцдаг асуудлын хүрээнд сургалтанд хамрагдахыг хүсч байна.

## 2.3 Чадавхийн бусад хэрэгцээ

Үнэлгээ болон бусад үйл ажиллагааны явцад анхаарлаа хандуулах шаардлагатай чадавхи бэхжүүлэх бусад олон хэрэгцээ байгааг тэд тодорхойлж байна. Тухайлбал:

### 2.3.1 Төсвийн төлөвлөлт

Сангийн яам цаашид ЦАС-гийн баг Засгийн газрын төсөв төлөвлөх үйл явцын талаарх мэдлэг, ойлголтоо дээшлүүлэх нь чухал гэж үзэж байна. Сангийн баг анх удаа Засгийн газрын төсвийн төлөвлөлт болон томоохон хэмжээний санхүүжилттэй сангийн хүрээнд ажиллаж байгаа болохоор тэд төсөв төлөвлөлтийн үйл явцын талаар илүү сайн мэдлэгтэй байх нь үйл ажиллагааг зөв оновчтой явуулахад туслах болно.

### 2.3.2 Эдийн засгийн загварчлал

Боловсруулсан түлшний туршилтын хөтөлбөрт маш ерөнхий тооцооны загварыг түлшний төлөвлөлтөнд ашигласан нь харагдсан. Иймд төслийн баг боловсруулсан түлшний туршилтын нарийвчилсан төлөвлөлтийн загварыг боловсруулан гаргаад байгаа билээ. ЦАС-гийн ажилтнууд болон цаашид уг загварыг ашиглах бусад байгууллагуудад холбогдох сургалт явуулах шаардлагатай.

### 2.3.3 Агаарын бохирдлын тухай үндсэн ойлголт

ЦАС-гийн баг агаарын бохирдлын тухай үндсэн ойлголтуудын талаар ямар нэг сургалтанд хамрагдаагүй байна. Ийм төрлийн сургалт нь тэдний ажлын хяналт, үйл ажиллагаанд тустай чухал үндэс суурийг тавьж өгөх болно. Агаарын бохирдлын талаарх анхан шатны сургалтын хөтөлбөрөөс гадна ЦАС-гийн ажилтнуудад тусгайлан гаргасан он-лайн сургалт байх нь зүйтэй. Түүнчлэн Сангийн бүх ажилтнууд УИХ-аар 2012-5 сард батлагдсан шинэ хууль тогтоомжийн сургалтанд хамруулах хэрэгтэй байна.

### 2.3.4 Мэдээлэл сурталчилгаа (Advocacy)

ЦАС нь үйл ажиллагааны мэдээлэл сурталчилгааг олон нийтэд хүргэхдээ ихэнхидээ зардал өндөртэй биет материал гаргах хэлбэрээр явуулж байна. Гэхдээ эдгээр материал, мэдээллийг он-лайн сүлжээний хэлбэрээр давхар хүргэж байх чухал гэж үзэж байна. Одоогоор мэдээлэл сурталчилгаа (advocacy)-ны тодорхой стратеги байхгүй, харилцаа холбооны асуудал хариуцсан ажилтангүй байна. Нэгэнт асуудал/сэдэв нь өөрөө хэвлэл мэдээллийн анхаарлын төвд байдаг чухал асуудлын нэг учраас ЦАС-гийн баг мэдээлэл сурталчилгаа, хэвлэл мэдээллийн талаар ерөнхийд нь сургалт авах нь тэдний үйл ажиллагаанд тустай. Үүнийг олон нийтийн зөвлөлдөх уулзалт, мэдээлэл сурталчилгаа (advocacy)-ны чиглэлээр хэрэгжүүлж байгаа төслийн үйл ажиллагаатай холбож болно.

### **2.3.5 Мониторинг, үнэлгээ**

Одоогоор ЦАС-гийн үйл ажиллагааны мониторинг, үнэлгээний тусгай төлөвлөгөө байхгүй байна. ЦАС нь маш их хэмжээний үйл ажиллагаа, тэдгээрийн төсөвт хяналт тавьж, Сангийн бараа, үйлчилгээний чанарыг хангах үүрэг хүлээдэг учраас уг төлөвлөгөөг гаргах хэрэгтэй гэж үзэж байна. Нэгэнт мониторинг, үнэлгээний төлөвлөгөө гаргах хэрэгтэй учраас уг төлөвлөгөөтэй холбоотой сургалтыг бас явуулах хэрэгтэй.

## 3 Чадавхи хөгжүүлэх үйл ажиллагааны ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд гаргасан ЦАС-гийн хүний нөөцийн бодлогод Сангийн ажилтнуудын хувийн үнэлгээний хуудас, журмыг оруулж, уг үнэлгээний хуудаст хувь хүний хөгжлийн асуудалтай холбоотой хэсгийг оруулсан. ЦАС-гийн ажилтнууд нь хувь хүний хөгжил, ур чадвараа дээшлүүлэх талаар ямар төлөвлөгөөтэй байгаагаа өөрсдийн ажлын төлөвлөгөөнд тусгах үүрэгтэй. Уг төлөвлөгөө нь сургалтын хэрэгцээний үнэлгээнд мөн үндэслэгдэх болно.

### 3.1 Сургалтын хөтөлбөрт тусгагдах асуудлууд

Сургалтын үйл ажиллагааг ЦАС-гийн ажилтнууд буюу төслийн багийн хүрээнд нэн тэргүүний гэж үзсэн асуудалд чиглүүлж байна. ЦАС-гийн ажилтнуудын хувьд олон улсын туршлага, жишээнээс суралцан өөрсдийн мэдлэг, ойлголтоо дээшлүүлэн, ЦАС-гийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, оновчтой болгоход өөрсдийн санаа бодлоо хуваалцан ажиллахыг нэн тэргүүнд тавьж байгаа нь харагдаж байна.

#### 3.1.1 Агаарын тухай хууль тогтоомж

Дээр дурьдсанчлан ЦАС-гийн ажилтнуудын сонирхож, чухал гэж үзэж буй асуудлын нэг нь агаарын тухай хууль тогтоомжийн асуудлаар олон улс (ялангуяа Европын орнууд)-ын туршлагаас суралцах юм. Иймд төслийн зүгээс олон улсын нэг хуульчид хандан агаарын тухайн олон улсын хууль тогтоомжийг судлан нэгдсэн тайлан гаргаж өгөх хүсэлт тавьсан:

Түүнчлэн бусад орнуудын туршлагаас суралцах боломж олгох үүднээс гадаадын улс орнуудад хийх 2 удаагийн танилцах аялалыг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Сангийн бүх ажилтнуудын дунд Агаарын тухай шинэ хуулийн талаар танилцуулга, мэдээлэл хийх хэрэгтэй бөгөөд энэ нь тэдэнд хууль эрх зүй, бодлого зохицуулалтын шинэ сүүлийн үеийн мэдээллээр хангахад тустай байх болно.

<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	Агаарын тухай хууль тогтоомжийн олон улс (ялангуяа Европын холбооны орнууд, олон улсын конвенциуд)-ын туршлагаас суралцах
<b>Сургалтын нөөц:</b>	УБЦАС- II/ЕСБХБ
<b>Хугацаа:</b>	2012-7 сар
<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	УБЦАС- II төслөөс олон улсын хууль тогтоомж, сайн туршлага, жишээний талаар ЦАС-гийн ажилтнуудад зориулсан сургалт
<b>Сургалтын нөөц:</b>	УБЦАС- II/ЕСБХБ
<b>Хугацаа:</b>	2012-8 сар

<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	Агаарын бохирдлын менежмент, тогтолцооны сайн жишээ бүхий орнуудад хийх 2 удаагийн танилцах аялал
<b>Сургалтын нөөц:</b>	ЦАС-гийн төсөв
<b>Хугацаа:</b>	2013

<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	Агаарын тухай шинэ хуулийн танилцуулга
-------------------------------	--

<b>Сургалтын нөөц:</b>	БОАЖЯ/УБЦАС II төсөл
<b>Хугацаа:</b>	2012-8 сар

### 3.1.2 Байгаль орчны санхүүжилт

Тус сангийн ажилтнуудын дурьдсан асуудлуудын нэг нь ЦАС-д хэрэглэж болох олон улсын санхүүжилтийн механизмуудын талаар илүү сайн ойлголттой болох явдал юм. ЦАС-г донор байгууллагуудаас санхүүжилт авч болно гэж заасан ч одоогоор донор байгууллагуудын санхүүжилтийг хэрхэн татах талаар тодорхой стратеги байхгүй, олон улсын санхүүжилтийн механизмд тавигддаг шаардлагуудын талаар мэдлэг, мэдээллээр хомс байна.

<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	Байгаль орчны олон улсын санхүүжилтийн механизмууд (жишээ нь: ДДБОС, Дасан зохицох сан, Дэлхийн банк, Германы засгийн газрын хөгжлийн банк гм)-ын талаар сургалтын хөтөлбөр боловсруулах
<b>Сургалтын нөөц:</b>	УБЦАС- II/ЕСБХБ
<b>Хугацаа:</b>	2012-8 сар
<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	Байгаль орчны олон улсын санхүүжилтийн механизмуудын талаар сургалт явуулах
<b>Сургалтын нөөц:</b>	УБЦАС- II/ЕСБХБ
<b>Хугацаа:</b>	2012-8 сар

### 3.1.3 Агаарын бохирдлын талаарх үндсэн ойлголт

ЦАС-гийн ажилтнууд агаарын бохирдлын менежментийн үндсэн зарчмуудын асуудлаар сургалтанд хамрагдаж байгаагүй. Иймд олон улсын өнөөгийн сургалтын хөтөлбөрт үндэслэн Сангийн бүх ажилтнуудад агаарын бохирдлын үндсэн асуудал, стандартуудын талаарх ойлголтыг дээшлүүлэх сургалтын товч хөтөлбөр гарган хэрэгжүүлж болох юм. АНУ-ын Байгаль хамгаалах агентлаг (дараах мэдээллийг харах)-аас явуулдаг Агаарын бохирдлын менежментийн он-лайн сургалтанд хамрагдахад ажилтнууд Англи хэлний хангалттай сайн мэдлэгтэй байх хэрэгтэй.

<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	Агаарын бохирдлын менежментийн үндсэн ойлголтуудын талаар сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтыг зохион байгуулах
<b>Сургалтын нөөц:</b>	УБЦАС- II/ЕСБХБ
<b>Хугацаа:</b>	2012-12 сар
<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	Агаарын бохирдлын тухай үндсэн ойлголтын тухай он-лайн сургалт
<b>Сургалтын нөөц:</b>	АНУ-ын Засгийн газар, төлбөргүй сургалт: <a href="http://www.epa.gov/apti/course422/index.html">http://www.epa.gov/apti/course422/index.html</a>
<b>Хугацаа:</b>	2012-7-12-р сар

## 3.2 Үйл ажиллагааны ба менежментийн асуудлууд

Цаашид ЦАС-гийн ажилтнуудыг сургаж, чадавхижуулах шаардлагатай олон асуудал, чиглэл байгааг тодорхойлоод байна. Суралцах шаардлагатай хамгийн чухал асуудалд төсөв бүрдүүлэх үйл явц, мониторинг үнэлгээ, санхүүгийн зохицуулалт, мэдээлэл сурталчилгаа / advocacy, харилцаа хамтын ажиллагаа, үндэсний хэмжээнд ажиллаж

байгаа бусад Тусгай сангуудын бүтэц гэсэн асуудлууд орж байна. Эдгээр асуудал, сэдвийн хүрээнд дараахи сургалтуудыг төлөвлөж байна. Үүнд:

<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	Төсөв бүрдүүлэлтийн үйл явцын талаар ЦАС-гийн ажилтнуудад мэдээлэл өгөх
<b>Сургалтын нөөц:</b>	УБЦАС- II/ЕСБХБ
<b>Хугацаа:</b>	2012-12 сар
<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	Засгийн газрын бусад сангуудын бүтэц, үйл ажиллагааг судлах,
<b>Сургалтын нөөц:</b>	УБЦАС- II/ЕСБХБ
<b>Хугацаа:</b>	2012-8 сар
<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	Мониторинг-үнэлгээний үндсэн ойлголтын он-лайн сургалт
<b>Сургалтын нөөц:</b>	АНУ-ын Засгийн газар, төлбөргүй сургалт: <a href="http://fa.usaidallnet.gov/fa-pme/viewhome.html">http://fa.usaidallnet.gov/fa-pme/viewhome.html</a>
<b>Хугацаа:</b>	2012-7-12-р сар
<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	ЦАС-гийн ажилтнуудад зориулсан Санхүүжилт/худалдан авалтын журмын танилцуулга
<b>Сургалтын нөөц:</b>	Сангийн яам
<b>Хугацаа:</b>	2012-9 сар
<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	Тендерийн журмын танилцуулга
<b>Сургалтын нөөц:</b>	Сангийн яам
<b>Хугацаа:</b>	2012-10 сар
<b>Үйл ажиллагааны төрөл:</b>	Мэдээлэл сурталчилгаа /Advocacy/-ны сургалт
<b>Сургалтын нөөц:</b>	Тодорхой болгох
<b>Хугацаа:</b>	2012-11 сар

### 3.3 Нөөц

Дээрх төлөвлөгөөнд заасны дагуу УБЦАС- II төслийн хүрээнд нэлээд олон сургалтын үйл ажиллагааг явуулж болохоор байна. Харин төслөөс гадуур явуулах бусад сургалтын үйл ажиллагааг ЦАС-гийн төсөв болон бусад эх үүсвэр, нөөцөөс санхүүжүүлэх хэрэгтэй. Холбогдох үйл ажиллагаанд ЦАС-д нөөцийг дайчлах, бүрдүүлэхэд УБЦАС- II төсөл тусалж болох юм. Ер нь сургалтанд зарцуулах төсвийг ЦАС-гийн 3 жилийн төсөв (Бүтээгдэхүүн 3.4.5)-д хангалттай тусгаж өгсөн. Санал болгож байгаа он-лайн сургалтууд нь төлбөргүй сургалтууд юм. Дараахи хүснэгтэд одоогоор үнэ төлбөргүй явагддаг он-лайн сургалтуудыг нэмэлт болгон оруулав.

#### Бусад он-лайн сургалтууд:

<b>Ашиглах нөөц</b>	<b>Сэдэ, асуудал:</b>
<a href="https://www.conservationtraining.org/">Байгаль хамгаалал/Conservation Online</a> ( <a href="https://www.conservationtraining.org/">https://www.conservationtraining.org/</a> )	Уур амьсгалын өөрчлөлт ТХГН-ууд ГЗМС Ус
Нэгдсэн Үндэстний их сургууль/ United Nations University	<a href="http://eia.unu.edu/course/?page_id=173">Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ/Environmental Impact Assessment</a> ( <a href="http://eia.unu.edu/course/?page_id=173">http://eia.unu.edu/course/?page_id=173</a> ) <a href="#">Байгаль орчны стратеги үнэлгэ/Strategic</a>

	<a href="http://onlinelearning.unu.edu/en/sea/">Environmental Assessment</a> ( <a href="http://onlinelearning.unu.edu/en/sea/">http://onlinelearning.unu.edu/en/sea/</a> )
Үйлдвэрлэлийн байгаль орчны эдийн засгийн олон улсын институт/ International Institute for Industrial Environmental Economics (IIIEE)	<a href="http://www.e4sd.org/home.htm">Energy for Sustainable Development</a> ( <a href="http://www.e4sd.org/home.htm">http://www.e4sd.org/home.htm</a> )



## Хавсралт 1 Нэмэлт тэмдэглэл

Гэрээний нэр:	Улаанбаатар Цэвэр агаар санаачлага – II үе – Төслийн хяналт удирдлага
Тайлангийн нэр:	Цэвэр агаарын сангийн ажилтнуудын сургалтын хэрэгцээний үнэлгээ ба үйл ажиллагааны төлөвлөгөө
Захиалагч:	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Захиалагчийн гэрээний Дугаар:	C22384/EBSF-2009-09-117/01
Захиалагчийн холбогдох мэдээлэл:	БОАЖЯ, Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн газар Засгийн газрын байр II Нэгдсэн Үндэстний гудамж 5/2 Улаанбаатар хот-210646 Монголия улс
Зөвлөх:	Евроконсалт Мотт Макдоналд Амстердамсевер 15, Арнхем Шуудангийн хайрцаг 441 6800 АК Арнхем Нидерланд улс Утас:+31 (0) 26 357 7111, Факс: +31 (0) 26 357 7577 И-мэйл: <a href="mailto:euroconsult@mottmac.nl">euroconsult@mottmac.nl</a> , веб хуудас: <a href="http://www.euroconsult.nl">www.euroconsult.nl</a>
Гэрээний менежер/ Төслийн захирал:	Каролин ла Чапелл И-мэйл: <a href="mailto:caroline.lachapelle@mottmac.nl">caroline.lachapelle@mottmac.nl</a>
Багийн ахлагч/ Төслийн менежер:	Пиет де Вилдт И-мэйл: <a href="mailto:piet.wildt@mottmac.nl">piet.wildt@mottmac.nl</a>